

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Хот тохижуулах газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2023/106/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Эрдэнэт хот

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах

Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Оргилмөрөн

Утас: 70357955 Цахим хаяг: orgilmurung@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2023.03.27 № 91
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ХОТ
ТОХИЖУУЛАХ ГАЗРЫН ДАРГА
Б.ОЮУНБАЯР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Хот тохижуулах газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Орхон аймгийн Хот тохижуулах газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Төсвийн тухай хуулийн цаглаварт хугацаанд санхүүгийн тайланг холбогдох материалын хамт ирүүлээгүй,
2. Аймгийн Засаг даргын 2022 оны А/527 дугаар захирамжаар Хот тохижуулах газарт эрх шилжүүлсэн "Цагаан тоосонцор бууруулах доройтсон ойг нөхөн сэргээх, зориудаар ойжуулах" арга хэмжээний гүйцэтгэгчийг гэрээ шууд байгуулах аргаар сонгон шалгаруулахдаа "ажлын даалгаварт" тусгасан чадварын шаардлага хангахгүй /3-аас доошгүй жил биологийн болон техникийн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулж байсан/ компанитай гэрээ байгуулж, гүйцэтгүүлсэн, гүйцэтгэлд олгосон 996,100.0 мянган төгрөгийн зардлыг үнэн зөв, бодитой илэрхийлсэн талаар үндэслэлтэй нотлох баримт олж авах боломжгүй тул хязгаарласан,
3. Тайлант онд 144,109.4 мянган төгрөгийн авлага, өр төлбөр үүсгэсэн,
4. Бодогдсон цалинг нийгмийн даатгалын шимтгэлийн болон татварын тайлан, мэдээнд алдаатай мэдүүлсэн, буруу тайлагнасан, цалингийн зардлаас зардлын

бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан зэрэг нь Төсвийн тухай хуулийн холбогдох заалттай нийцэхгүй, бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Орхон аймгийн Хот тохижуулах газар нь 2022 оны санхүүгийн тайлангийн хугацаанд орон нутгийн төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 5,278,200.9 мянган төгрөг үндсэн дансанд хүлээн авч зардлын зүйл ангиар зарцуулж хэмнэлтийг бүрэн төвлөрүүлсэн байна. Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн тохижилт, засвар, тоног төхөөрөмжийн парк шинэчлэлийн ажлуудын хүрээнд 10,198,790.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн байна. Дээрх онцгойлсон асуудалтай холбоотой аудиторын дүгнэлт өөрчлөгдөөгүй болно.

Аудитын гол асуудал

Орхон аймгийн Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн 03 дугаар тогтоолоор Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоож, 2022 оны 01 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн байна. Хог хаягдлын төлбөр хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан 2022 онд орон нутгийн төвлөрүүлэх орлогын хэмжээг өмнөх оноос 2.6 дахин нэмэгдүүлж баталсан бөгөөд биелэлтийг хангаж ажилласан байна. Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 07/04 дугаар тогтоолоор “Хог хаягдлын менежментийг сайжруулах” хөтөлбөрийг батлуулж, хөтөлбөрийн хүрээнд 1,094,011.0 мянган төгрөгийн тусгай тоноглол бүхий 4ш хог ачих зориулалттай ачааны автомашинаар парк шинэчлэл хийсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>172,170,211.50</u>	<u>281,144,159.32</u>
33	АВЛАГА	21,790,818.50	3,725,191.28
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	21,790,818.50	3,725,191.28
35	БАРАА МАТЕРИАЛ	150,379,393.00	277,418,968.04
351	Түүхий эд материал	47,632,866.00	72,308,100.00
35110	Тусгай зориулалттай материал	47,632,866.00	72,308,100.00
354	Хангамжийн материал	102,746,527.00	205,110,868.04
35410	Бичиг хэргийн материал	25,000.00	302,750.00
35420	Аж ахуйн материал	27,755,505.00	86,743,570.04
35430	Сэлбэг хэрэгсэл	13,487,724.00	13,121,500.00
35450	Барилгын засварын материал	32,408,800.00	85,130,975.00
35460	Хүнсний материал	0.00	5,140,575.00
35470	Бусад хангамжийн материал	29,069,498.00	14,671,498.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>36,838,332,758.09</u>	<u>41,711,193,644.68</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	36,838,332,758.09	41,711,193,644.68
392	Биет хөрөнгө	36,332,132,758.09	41,204,993,644.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,246,390,606.29	1,246,390,606.29
39202	Хуримтлагдсан элэгдэл	-356,223,151.70	-415,809,677.58
39203	Авто-тээврийн хэрэгсэл	3,777,022,851.00	4,685,461,508.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-3,459,829,454.24	-3,477,610,374.80
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	163,886,626.00	217,435,037.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-98,458,065.69	-115,883,167.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	117,637,576.00	117,637,576.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-71,123,010.88	-74,915,454.23
39209	Зам, гүүрийн байгууламж	36,556,487,487.06	42,179,152,927.06
39210	Хуримтлагдсан элэгдэл	-14,893,274,852.74	-18,688,994,202.26
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,439,201,395.88	21,952,313,856.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,089,585,248.89	-6,420,184,990.20
393	Биет бус хөрөнгө	506,200,000.00	506,200,000.00
39301	Программ хангамж	1,562,000.00	1,562,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,562,000.00	-1,562,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	506,200,000.00	506,200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>37,010,502,969.59</u>	<u>41,992,337,804.00</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>26,693,556.00</u>	<u>140,384,190.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	26,693,556.00	140,384,190.00
413	Өглөг	26,693,556.00	140,384,190.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,750.00	130,036,690.00
4136	Бусад өглөг	26,689,806.00	10,347,500.00
41361	Байгууллагад төлөх өглөг	20,987,106.00	9,250,600.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	5,702,700.00	1,096,900.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>36,983,809,413.59</u>	<u>41,851,953,614.00</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	36,983,809,413.59	41,851,953,614.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	7,235,927,847.02	7,235,927,847.02
51101	Өмч: - төрийн	7,235,927,847.02	7,235,927,847.02
512	Хуримтлагдсан үр дүн	24,362,232,848.96	29,230,377,049.37
51210	Өмнөх үеийн үр дүн	18,301,324,229.71	24,362,232,848.96
51220	Тайлант үеийн үр дүн	6,060,908,619.25	4,868,144,200.41
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,385,648,717.61	5,385,648,717.61

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>37,010,502,969.59</u>	<u>41,992,337,804.00</u>
---	--	---------------------------------	---------------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	16,565,462,584.80	17,353,616,278.52
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,275,154,384.80	10,227,375,078.52
120	Нийтлэг татварын бус орлого	11,275,154,384.80	10,227,375,078.52
120017	Үнэ төлбөргүй хүлээн үндсэн хөрөнгө	11,240,559,759.80	10,198,789,968.52
120018	Үнэ төлбөргүй хүлээн бараа материал	34,594,625.00	28,585,110.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,290,308,200.00	7,126,241,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	275,122,900.00	250,721,900.00
131008	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	275,122,900.00	250,721,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	617,682,100.00	1,848,040,300.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	617,682,100.00	1,847,515,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагаанаас бий болсон нэмэлт орлого		525,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	4,397,503,200.00	5,027,479,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	4,397,503,200.00	5,027,479,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	10,432,077,963.60	12,485,472,078.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,432,077,963.60	12,485,472,078.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,292,903,388.66	11,983,575,749.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,941,762,653.63	1,986,919,680.12
210101	Үндсэн цалин	1,499,570,462.30	1,537,504,598.13
210102	Нэмэгдэл	442,192,191.33	386,581,583.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт		16,331,688.35
210104	Урамшуулал		46,501,810.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	318,894,781.00	270,408,955.99
210201	Тэтгэврийн даатгал	182,901,224.61	168,633,647.04
210202	Тэтгэмжийн даатгал	18,650,500.00	19,728,059.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	76,312,057.07	41,239,755.66
210204	Ажилгүйдлийн даатгал	3,730,100.00	3,582,350.59
210205	Эрүүл мэндийн даатгал	37,300,899.32	37,225,143.63
2103	Байр ашиглалттай холбоотой зардал	51,215,996.00	62,322,000.00
210301	Гэрэл, цахилгаан	11,016,676.00	9,421,850.00
210302	Түлш, халаалт	26,884,075.00	39,009,529.00
210303	Цэвэр, бохир ус	12,915,245.00	13,890,621.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,032,921,263.00	1,446,407,461.72
210401	Бичиг хэрэг	6,433,434.00	5,666,110.00
210402	Тээвэр, шатахуун	903,078,820.00	1,353,774,970.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,039,659.00	2,537,051.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	25,660,000.00	70,281,050.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	95,709,350.00	14,148,280.72
2105	Нормативт зардал	37,136,505.00	93,112,835.24
210502	Хоол, хүнс	31,373,955.00	33,463,460.06
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,762,550.00	59,649,375.18
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	139,681,646.00	302,126,687.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,905,600.00	36,273,535.00

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	63,912,277.00	66,853,450.00
210604	Урсгал засвар	62,863,769.00	198,999,702.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,592,958,398.64	2,486,747,447.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,507,386,803.64	2,406,762,295.10
210803	Даатгалын үйлчилгээ	12,148,895.00	12,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,114,800.00	3,492,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,123,600.00	1,089,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,000,000.00	0.00
210807	Газрын төлбөр	64,184,300.00	62,903,852.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,178,332,145.39	5,335,530,681.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		9,601,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,207,700.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,157,124,445.39	5,325,929,081.93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	139,174,574.94	501,896,329.01
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	250,721,900.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		250,721,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	133,349,385.00	209,114,663.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	115,402,000.00	196,201,563.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,947,385.00	12,913,100.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,825,189.94	42,059,766.01
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,149,618.64	39,102,892.48
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	675,571.30	2,956,873.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	6,133,384,621.20	4,868,144,200.41
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	72,476,001.95	0.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	72,476,001.95	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-72,476,001.95	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	6,060,908,619.25	4,868,144,200.41

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	5,290,308,200.00	7,126,241,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,290,308,200.00	7,126,241,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	275,122,900.00	250,721,900.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	275,122,900.00	250,721,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	617,682,100.00	1,848,040,300.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	617,682,100.00	1,847,515,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		525,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	4,397,503,200.00	5,027,479,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	4,397,503,200.00	5,027,479,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	5,264,008,200.00	7,126,241,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,264,008,200.00	7,126,241,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,124,833,625.06	6,624,344,870.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,964,040,472.13	1,986,944,436.72

210101	Үндсэн цалин	1,521,848,280.80	1,537,504,598.13
210102	Нэмэгдэл	442,192,191.33	386,606,340.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт		16,331,688.35
210104	Урамшуулал		46,501,810.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	294,804,023.93	270,868,449.27
210201	Тэтгэврийн даатгал	182,901,224.61	168,633,647.04
210202	Тэтгэмжийн даатгал	18,650,500.00	19,783,703.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	52,221,300.00	41,605,389.72
210204	Ажилгүйдлийн даатгал	3,730,100.00	3,620,565.57
210205	Эрүүл мэндийн даатгал	37,300,899.32	37,225,143.63
2103	Байр ашиглалттай холбоотой зардал	51,932,714.00	62,322,000.00
210301	Гэрэл, цахилгаан	9,989,224.00	9,600,000.00
210302	Түлш, халаалт	27,609,973.00	38,959,707.00
210303	Цэвэр, бохир ус	13,933,517.00	13,762,293.00
210304	Байрны түрээс	400,000.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	866,086,263.00	1,217,196,221.00
210401	Бичиг хэрэг	4,284,789.00	5,416,200.00
210402	Тээвэр, шатахуун	787,775,615.00	1,124,667,570.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,039,659.00	2,537,051.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	59,521,500.00	70,549,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,464,700.00	14,025,600.00
2105	Нормативт зардал	83,323,955.00	100,121,686.00
210502	Хоол, хүнс	31,373,955.00	40,484,450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	51,950,000.00	59,637,236.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	207,122,456.00	296,345,650.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	35,815,000.00	35,815,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	84,240,427.00	67,618,200.00
210604	Урсгал засвар	87,067,029.00	192,912,450.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,633,155,959.00	2,680,946,028.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,552,584,364.00	2,600,960,876.00
210803	Даатгалын үйлчилгээ	12,148,895.00	12,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,114,800.00	3,492,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,123,600.00	1,089,000.00
210807	Газрын төлбөр	64,184,300.00	62,903,852.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,367,782.00	9,600,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		9,600,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,367,782.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	139,174,574.94	501,896,329.01
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	250,721,900.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		250,721,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	133,349,385.00	209,114,663.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж	115,402,000.00	196,201,563.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,947,385.00	12,913,100.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,825,189.94	42,059,766.01
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,149,618.64	39,102,892.48
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	675,571.30	2,956,873.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>26,300,000.00</u>	<u>0.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>26,300,000.00</u>	<u>0.00</u>

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	26,300,000.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	26,300,000.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	26,300,000.00	0.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-26,300,000.00</u>	<u>0.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020.12.31-нээрх үлдэгдэл	7,235,927,847.02	5,385,648,717.61	17,856,322,966.62	30,477,899,531.25
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,235,927,847.02	5,385,648,717.61	17,856,322,966.62	30,477,899,531.25
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	445,001,263.09	445,001,263.09
C08	2021.12.31-нээрх үлдэгдэл	7,235,927,847.02	5,385,648,717.61	18,301,324,229.71	30,922,900,794.34
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,235,927,847.02	5,385,648,717.61	18,301,324,229.71	30,922,900,794.34
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,235,927,847.02	5,385,648,717.61	24,362,232,848.96	36,983,809,413.59
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	4,868,144,200.41	4,868,144,200.41
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,235,927,847.02	5,385,648,717.61	29,230,377,049.37	41,851,953,614.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,278,200,900.00	5,239,098,007.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,278,200,900.00	5,239,098,007.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,819,729,900.00	4,781,386,744.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,875,156,500.00	1,874,866,836.70
210101	Үндсэн цалин	1,504,110,800.00	1,444,629,661.40
210102	Нэмэгдэл	371,045,700.00	371,045,699.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	14,854,088.35
210104	Урамшуулал	0.00	44,337,387.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	289,082,200.00	258,298,172.82

210201	Тэтгэврийн даатгал	177,179,400.00	160,720,509.63
210202	Тэтгэмжийн даатгал	18,650,500.00	18,945,824.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	52,221,300.00	39,629,099.35
210204	Ажилгүйдлийн даатгал	3,730,100.00	3,453,354.48
210205	Эрүүл мэндийн даатгал	37,300,900.00	35,549,385.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,322,000.00	62,322,000.00
210301	Гэрэл, цахилгаан	9,600,000.00	9,600,000.00
210302	Түлш, халаалт	38,500,000.00	38,959,707.00
210303	Цэвэр, бохир ус	13,722,000.00	13,762,293.00
210304	Байрны түрээс	500,000.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,049,107,000.00	1,047,084,651.00
210401	Бичиг хэрэг	4,000,000.00	4,256,000.00
210402	Тээвэр, шатахуун	955,986,200.00	955,986,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,673,200.00	2,537,051.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	70,549,800.00	70,549,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,897,800.00	13,755,600.00
2105	Нормативт зардал	90,249,300.00	90,237,236.00
210502	Хоол, хүнс	35,500,000.00	35,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	54,749,300.00	54,737,236.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	262,056,000.00	260,958,720.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	35,815,000.00	35,815,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	62,518,800.00	62,518,800.00
210604	Урсгал засвар	163,722,200.00	162,624,920.00
2107	Томилолт, зочны зардал	215,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	215,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,191,541,900.00	1,187,619,128.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,112,578,300.00	1,112,234,476.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,280,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	8,518,500.00	8,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,970,800.00	2,970,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,010,000.00	1,010,000.00
210807	Газрын төлбөр	64,184,300.00	62,903,852.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	458,471,000.00	457,711,263.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	250,721,900.00	250,721,900.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	250,721,900.00	250,721,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	207,749,100.00	206,989,363.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж	196,799,100.00	196,201,563.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,950,000.00	10,787,800.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,278,200,900.00	5,239,098,007.52
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	250,721,900.00	250,721,900.00
131008	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	250,721,900.00	250,721,900.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,027,479,000.00	4,988,376,107.52
132001	Орон нутгийн төсвөөс	5,027,479,000.00	4,988,376,107.52
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	243.00	243.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00
620003	Үйлчлэх ажилтан	224.00	224.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	243.00	243.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	243.00	243.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	617,682,100.00	1,848,040,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	617,682,100.00	1,848,040,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	610,006,528.70	1,842,958,126.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	98,994,473.09	112,077,600.00
210101	Үндсэн цалин	86,257,965.70	92,874,936.71
210102	Нэмэгдэл	12,736,507.39	15,560,640.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт		1,477,600.00
210104	Урамшуулал		2,164,423.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,721,824.61	12,570,276.47
210201	Тэтгэврийн даатгал	5,721,824.61	7,913,137.41
210202	Тэтгэмжийн даатгал		837,879.21
210203	ҮОМШӨ-ний даатгал		1,976,290.37
210204	Ажилгүйдлийн даатгал		167,211.09
210205	Эрүүл мэндийн даатгал		1,675,758.39
2104	Хангамж, бараа материалын зардал	121,580,040.00	170,111,570.00
210401	Бичиг хэрэг	433,000.00	1,160,200.00
210402	Тээвэр, шатахуун	120,557,040.00	168,681,370.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	590,000.00	270,000.00
2105	Нормативт зардал	2,700,000.00	9,884,450.00
210502	Хоол, хүнс		4,984,450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,700,000.00	4,900,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,867,520.00	35,386,930.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,490,600.00	5,099,400.00
210604	Урсгал засвар	23,376,920.00	30,287,530.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	333,142,671.00	1,493,326,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	328,877,176.00	1,488,726,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,630,395.00	4,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	521,500.00	521,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	113,600.00	79,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,000,000.00	9,600,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,000,000.00	9,600,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,000,000.00	2,125,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,000,000.00	2,125,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,000,000.00	2,125,300.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	675,571.30	2,956,873.53
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	675,571.30	2,956,873.53
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	617,682,100.00	1,848,040,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	617,682,100.00	1,848,040,300.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	617,682,100.00	1,847,515,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		525,000.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 1,216,837.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 11,174.5 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, худалдан авах ажиллагаатай холбоотой болон өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй 1,014,002.1 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 191.7 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

1. Байгууллагын даргын цалин, ээлжийн амралтын цалинг давхардуулан нийт 1,002.8 мянган төгрөг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Хөдөлмөрийн тухай хуулийн 99.1-д "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно", 110.2-д "Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд ээлжийн амралтын цалинг нэг аравны тав дахин нэмэгдүүлж олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 1.2-д "Ажил олгогч нь тухайн ажлын жилийн ээлжийн амралтын хуваарийг ажилтны саналыг үндэслэн ажил, үйлчилгээ, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байдлаар зохион байгуулж, жил бүрийн нэгдүгээр улиралд батална" гэж заасантай нийцэхгүй байна.

2. Нэгдсэн үндэстний байгууллагын хөтөлбөрөөр олгож буй дахивар хог хаягдлын тоног төхөөрөмжийг хадгалах гурван сая төгрөгийн гражийн төлбөрийн гэрээг иргэнтэй байгуулан тайлант онд 900.0 мянган төгрөгийн түрээсийн төлбөр төлсөн байна. Энэ Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэж заасантай нийцэхгүй байна.

3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цалингаас суутгасан татвар болон зарим ажилтны татварын хөнгөлөлтийн тооцоог цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайлан, мэдээнд удаа дараа алдаатай бэлтгэн илгээж, тайлант онд 9,271.7 мянган төгрөгийн илүү татвар ногдуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Татварын ерөнхий хуулийн 26.5-д "Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд байгаа татвар төлөгчийн мэдээлэл тухайн татвар төлөгчид нээлттэй байх ба мэдээллийн үнэн зөвийг татвар төлөгч хариуцна", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25.3-д "Суутган төлөгч нь хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогод албан татвар ногдуулахад холбогдох нотлох баримтыг үндэслэн энэ хуулийн 22.1.2-т заасан чөлөөлөлтийг хасаж тооцно", 25.7-д "Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн энэ хуулийн 21.1-д заасны дагуу ногдох албан татвар, 23.1-д заасны дагуу эдлэх хөнгөлөлтийг жилийн эцсийн тайлангаар эцэслэн тооцож тайлагнан, холбогдох татварыг төсөвт шилжүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

3.2 Албан шаардлага

1. Нийгмийн даатгалын шитгэлийн тайланд бодогдсон цалинг 3,243.5 мянган төгрөгөөр илүү мэдүүлсэн, цалингийн зардлаас ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 14,658.6 мянган төгрөг гүйлгэн зарцуулсан, цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус

орлогод ногдуулан суутгасан албан татварын тайлан, мэдээг алдаатай бэлтгэсэн зэрэг өмнө оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Сангийн сайдын 2018 оны 134 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 3.1.6-д “Төсвийн тухай хуулийн 42.4-т заасны дагуу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх” гэж заасантай нийцэхгүй байна.

2. Аймгийн Засаг даргын 2022 оны А/527 дугаар захирамжаар Хот тохижуулах газарт эрх шилжүүлсэн "Цагаан тоосонцор бууруулах доройтсон ойг нөхөн сэргээх, зориудаар ойжуулах" 1,000,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй арга хэмжээний гүйцэтгэгчийг гэрээ шууд байгуулах аргаар сонгон шалгаруулахдаа "ажлын даалгаварт" тусгасан чадварын шаардлага хангахгүй /3-аас доошгүй жил биологийн болон техникийн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулж байсан/ компанитай гэрээ байгуулж, гүйцэтгүүлж 996,100.0 мянган төгрөг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.2-д "Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхтай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана" гэж заасантай нийцэхгүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлага, өр төлбөрийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллага нь өмнөх онуудад үүссэн авлага, өр төлбөрийг бүрэн барагдуулсан боловч, тайлант онд НДШ, ХХОАТ-ийн 3,725.2 мянган төгрөгийн авлага, дээд удирдлагаас өгсөн шинэ жилээр айл өрхийн хог хаягдлыг бүрэн татах, талбайн гацуур модны өнгө төрхийг шинэчлэн засах чиглэлийн хүрээнд 140,384.2 мянган төгрөгийн өр төлбөр шинээр үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах.

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус газрын санхүүгийн тайланд бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдэд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.4-д "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй авто тээврийн хэрэгслүүдийн улсын дугаарыг бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгөтэй болгох.

3. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цалингийн зардлаас 2022 оны 12-р сард гудамжны гэрэлтүүлгийн ажилчдын цалинд “Эрдэнэт-Ус ДТС” ОНӨХК-руу нийт 46,779.3 мянган төгрөг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудтай нийцэхгүй, Сангийн сайдын 2018 оны 134 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 3.1.6-д “Төсвийн тухай хуулийн 42.4-т заасны дагуу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цалингийн зардлыг зориулалтын дагуу зарцуулах.

4. Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллагын программ хангамжийн дансанд элэгдлээрээ өртгөө нөхсөн, цалингийн нэгдсэн системд шилжсэнтэй холбоотойгоор цаашид ашиглахгүй болсон 772.0 мянган төгрөгийн цалингийн систем, санхүүгийн программ хангамжууд бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.4-д "Энэ хуулийн 4.1.3-т заасан стандартыг Төсвийн тухай хуулийн 4.1.34-т заасан байгууллага мөрдөнө" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шинэчлэгдэн өөрчлөгдөж цаашид ашиглагдахгүй болсон элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн программ хангамжийг актлах санал хүргүүлж хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орхон аймгийн Хот тохижуулах газар	1	1,002.8	1	1,002.8								
	1	9,271.7	1	9,271.7								
	1	144,109.4					1	144,109.4				
	1	900.0	1	900.0								
	1	17,902.1			1	17,902.1						
	1	0.0					1	0.0				
	1	46,779.3					1	46,779.3				
	1	772.0					1	772.0				
	1	996,100.0			1	996,100.0						
Дүн	9	1,216,837.3	3	11,174.5	2	1,014,002.1	4	191,660.7				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		